Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2013 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь 4 бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна. НББ-ийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөхоноос 29,443.6 мянган төгрөгөөр буюу 0,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,521.2 | 121,529.9 | 120,008.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 39,666.0 | 49,401.2 | 9,735.2 |
| Үндсэн хөрөнгө | 5,109,877.0 | 4,950,689.6 | (159,187.5) |
| Нийт хөрөнгө | 5,151,064.3 | 5,121,620.7 | (29,443.6) |
| Өр төлбөр | 25,279.3 | - | (25,279.3) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 5,125,785.0 | 5,121,620.7 | (4,164.3) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 5,151,064.3 | 5,121,620.7 | (29,443.6) |

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 99.2 мянган төгрөг, аж ахуйн материал 22,696.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, сэлбэг хэрэгсэл 3,120.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,400.0 мянган төгрөг, мал амьтад 8,540.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс тайлант онд барилга байгууламж орон сууц 217,353.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 2,693.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 18,806.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 73,777.0 мянган төгрөгийн хөрөнгийн данснаас актлан буурсан байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 14,483.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 18,991.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 15,685.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 19,423.0 мянган төгрөгийн номын фонд, 3,223.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 217,353.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 43,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 10,760.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 10,760.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Оны эхэнд өглөгийн данс 25,279.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан нь түлш халаалтынтооцоо 3,074.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны тооцоо 6,007.3 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 16,197.5 мянган төгрөгийн өглөг үүссэн байна. Энэ нь сумын төвийн гэрэлтүүлэг 18ш цамхагт гэрэл суурилуулж угсралт хийснээр Засаг даргын Тамгын газрын цахилгааны төлбөр нэмэгдсэнээс үүсэн байна. Ану сервис буюу түлш халаалтын өглөг нь үнэ тарифын зөрүүгээс үүссэн байна. Тайлант онд уг өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Оны эхэнд авлагын данс 1,521.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан нь тайлант онд тээвэршатахууны авлага 91.2 мянган төгрөг, “Сүмбэр өгөөж” ХХК-тай тэжээлийн тооцооны 1,430.0 мянган төгрөг тус тус байсан байна. Тайлант онд 1,521.2 мянган төгрөгийн авлага барагдаж шинээр 120,008.6 мянган төгрөг авлага үүссэн байна. Энэ төрийн албан хаагчдын орон сууцны барилгыг хүлээж аваагүй байгаа тул урьдчилгаа болох 70 хувийн санхүүжилт 119,051.1 мянган төгрөгийг авлагаар, иргэдэд худалдан борлуулсан өвсний үнэ болох 957.4 мянган төгрөгийг тус тус авлагаар бүртгэж санхүүгийн тайланд тусгасан байна.

Засгийн газрын оролцооны дансны үлдэгдэл 5,121,621.0 мянган төгрөг болж 4,164.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 697,274.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралтаар 77,775.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Харин 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 01 дугаар тогтоолоор урсгал зардлын төсвийг 751,245.7 мянган төгрөг болгож 131,746.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 /орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/ хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 751,245.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсандагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй

үлдэгдэл 17,191.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 734,054.1 мянган төгрөг буюу 97,7 хувийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал | 447,132.2 | 448,832.2 | -1,700.0 | 100.4 |
| 2 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 74,700.0 | 74,700.0 | 0.0 | 100.0 |
| 3 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 78,141.7 | 76,441.7 | 1,700.0 | 97.8 |
| 4 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 17,590.0 | 17,590.0 | 0.0 | 100.0 |
| 5 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад | 97,781.8 | 97,781.8 | 0.0 | 100.0 |
| 6 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө | 13,500.0 | 13,500.0 | 0.0 | 100.0 |
| 7 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам | 5,000.0 | 5,000.0 | 0.0 | 100.0 |
| 8 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 9,500.0 | 9,500.0 | 0.0 | 100.0 |
| 9 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 7,900.0 | 7,900.0 | 0.0 | 100.0 |
| | Дүн | 751,245.7 | 751,245.7 | 0.0 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийнбүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 232,867.5 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 2,500.0 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 11,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 46,279.0 мянган төгрөг хөрөнгө нийт 242,647.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдад олгосон орон нутгийн нэмэгдэл 40,666.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 5,994.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 7,760.0 мянган төгрөг, урсгал засварт 29,399.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 38,289.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 128,321.4 мянган төгрөг нийт 249,520,5 мянган төгрөг зарцуулж, 43,126.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 45,899,363.00 | **292,647,185.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 45,899,363.00 | 292,647,185.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 36,187,763.00 | 249,520,473.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.00 | 40,666,800.15 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 5,245,124.43 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 29,427,515.72 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 5,994,160.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.00 | 5,083,349.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 3,709,981.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 406,667.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 325,334.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 81,333.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 560,032.72 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.00 | 7,760,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 760,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 7,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 29,399,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 29,399,150.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,105,580.00 | 38,289,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,105,580.00 | 38,289,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,639,487.00 | 128,321,473.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,639,487.00 | 128,321,473.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,701,600.00 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,701,600.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,201,600.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,371,400.00 | 0.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,371,400.00 | 0.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 7,371,400.00 | 0.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 43,126,711.88 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 43,126,711.88 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **45,899,363.00** | **292,647,185.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 45,899,363.00 | 292,647,185.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0.00 | 2,500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 11,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,899,363.00 | 232,867,552.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 46,279,633.00 |

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөнбайна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал | 2023.01.01 2023.12.31 | | | 447,132.2 | 448,832.2 |
| 2 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80103 /Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | | 74,700.0 | 74,700.0 |
| 3 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80106 /Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Баг, хорооны үйл ажиллагааны зардал | | 78,141.7 | 76,441.7 |
| 4 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | | 17,590.0 | 17,590.0 |
| 5 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80918 /Бусад | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Бусад | | 97,781.8 | 97,781.8 |
| 6 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 81102 /Орон | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон | | 13,500.0 | 13,500.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нутгийн нөөц хөрөнгө | | нутгийн нөөц хөрөнгө | | | |
| 7 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82801 /Улсын их баяр наадам | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам | | 5,000.0 | 5,000.0 |
| 8 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81701 /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | | 9,500.0 | 9,500.0 |
| 9 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | | 7,900.0 | 7,900.0 |
| | Дүн | | | | 751,245.7 | 751,245.7 |

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 60,318.4 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

### 3.5.5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А/01 тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгө оруулалтаар 363,418.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар тусгасан байна. Худалдан авах ажиллагааны журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгаж ажилласан байна

# 4 АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоодхяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06/56 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,345,722.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 20,186.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,149.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох гэсэн" заалтыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 9,454.2 мянган төгрөг олгосон байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн

хэрэгжилтийг шалгахад нийт 166 мэдээлэл оруулахаас 165 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36 орлогын, 13 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээллийн байршуулалт 74,2 хувьтай байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилдүндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1** Завсрын аудитын талаар

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад алдаа зөрчил илрээгүй болно.

**4.5.2** Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 03/221 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,521.0 | 1 | 1,521 .0 | 100 |
| Албан шаардлага | 2 | 27,831.0 | 2 | 27,831.0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 19,950.0 | 1 | 19,950.0 | 100 |
| Нийт дүн | 4 | 49,302.0 | 4 | 49,302.0 | 100 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд "Монголын баялаг 330" төсөл хөтөлбөрийн хүрээнд соёлын өвийг дүрсжүүлэн архив, үүсгэх ажлын гэрээний дагуу Монголын баялаг өв соёл ХХК-д 3,879.6 мянган төгрөг шилжүүлсэн байна. Холбогдох баримт материалыг хүлээн авч орлого болгосон талаарх асуудлыг авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Лүн сумын Засаг даргын Тамгын газрын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудитаар 95,722.8 мянган төгрөгийн алдаа, 836,686.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлснийг дараах байдлаар шийдвэрлэлээ.[1]

### 5.1 Залруулсан алдаа

**1.Илрүүлэлт:** Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгийн дүнг салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

**2.Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалтай тулгахад 23,917.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулгахийгдсэн.

Аудитаар нийт 836,686.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 9,454.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 827,232.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, хүргүүллээ[2].

### 5.2 Төлбөрийн акт

**1. Илрүүлэлт:** Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгоно гэсэн Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 9,454.2 мянган төгрөг олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар "Журам батлах тухай" тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй

---

[1] *Мэдээллийг тусгаахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл*

байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

**5.3 Албан шаардлага**

1.**Илрүүлэлт:** Өмнөх оны ЗДТГ-ын холболтын зургийн үлдэгдэл санхүүжилт 30% болох 9,000.0 мянган төгрөгийг Сонголт дизайн ХХК-д өглөг үүсгэлгүйгээр шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаарзүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**2. Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 36 мөнгөн гүйлгээ болон 5 сая төгрөгөөс дээш зарлагын 2 мөнгөн гүйлгээг байршуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

Дээрх зөрчлийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаарсарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлагналтай холбоотой алдаа | 2 | 95,722.8 | 2 | 95,722.8 | | | 2 | 95,722.8 | | | | |
| **Дүн** | 2 | 95,722.8 | 2 | 95,722.8 | | | 2 | 95,722.8 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Монгол улсын Засгийн газрын тогтоолыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгосон. | 1 | 9,454.2 | 1 | 9,454.2 | | | | | | | | |
| Өмнөх оны ЗДТГ-ын холболтын зургийн үлдэгдэл санхүүжилт 30% болох 9,000.0 мянган төгрөгийг өглөг үүсгээгүй. | 1 | 9,000.0 | | | 1 | 9,000.0 | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 818,232.7 | | | 1 | 818,232.7 | | | | | | |
| **Дүн** | **3** | **836,686.9** | **1** | **9,454.2** | **0** | **827,232.7** | | | | | | |